

**ТӨСВИЙН ШУУД ЗАХИРАГЧИЙН
2019 ОНЫ САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛД
ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ**

Товчилсон үгийн жагсаалт

УСНББОУС	Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт
АДБОУС	Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт
АОУС	Аудитын Олон Улсын Стандарт
ТӨБЗГ	Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газар
БСШУСС	Боловсрол соёл, шинжлэх ухаан спортын сайд

Агуулга

1.Аудитын гэрчилгээ	3
2.Аудитын тайлан	5
2.1. Оршил	5
2.2. Аудит хийх үндэслэл, зорилго, талуудын хүлээх үүрэг, хариуцлага.....	5
2.3. Аудитад мөрдсөн бодлого, журам, арга зүй, шалгуур үзүүлэлт.....	5
2.4. Байгууллагын зорилго, үйл ажиллагаа, хууль, эрх зүйн орчин	6
2.5. Нягтлан бодох бүртгэлийн бодлого, санхүүгийн үйл ажиллагаа болон дотоод хяналттай холбоотой хүчин зүйлсийн үнэлгээ.....	6
2.6. Төлөвлөлтийн шатанд тодорхойлсон эрсдэл, түүнийг үнэлсэн байдал	7
2.7. Материаллаг байдлын суурь сонгосон үндэслэл, тайлбар	7
2.8. Санхүүгийн тайлангийн үзүүлэлтүүд	7
2.9. Төсвийн гүйцэтгэлийн талаарх тайлбар, тодруулга	8
2.10. Аудитаар хэрэгжүүлсэн горим сорил, түүний үр дүн	8
2.11. Дараагийн аудитаар авч үзэх буюу анхаарал татахуйц бусад чухал асуудал.....	8
2.12. Шилэн дансны мэдээлэл.....	9
2.13. Өмнөх аудитаар өгсөн акт, албан шаардлага, зөвлөмжийн хэрэгжилт	9
2.14. Дүгнэлтийн хэлбэр, үндэслэл	9
3.Менежментийн захидал	10
4.Аудит хийсэн санхүүгийн тайлан	12
4.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан	12
4.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан	13
4.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан.....	14
4.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан.....	16
4.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан.....	17
4.6 Аудит хийсэн нэмэлт санхүүжилтийн тайлан.....	19
5.Аудитын явцад илэрсэн алдаа, зөрчлийн нэгтгэл	17



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР

15160 Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг
Бага тойруу-3, Засгийн газрын IV байр
Утас:26-04-37, Факс:51-26-42-30
E-mail: info@audit.gov.mn

2020 02.21 № 06/595
танай _____-ны № _____-т

Аудитын гэрчилгээ

Төрийн аудитын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1, 18 дугаар зүйлийн 18.2, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Монгол тэмүүлэл сургуулийн 2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд санхүүгийн тайлангийн аудит хийв.

Зөрчилгүй санал дүгнэлт

Монгол тэмүүлэл сургуулийн 2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээ болон төсвийн гүйцэтгэлийн тайланг материаллаг зүйлсийн хувьд Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, УСНББОУС-д нийцүүлж, Сангийн сайдын баталсан бодлого, журам, зааврын дагуу үнэн, бодитой, шударга илэрхийлсэн тул зөрчилгүй санал дүгнэлт гаргаж байна.

Санал дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагуудын нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчим, стандарт болон Аудитын олон улсын стандартад нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторовын баталсан Санхүүгийн тайлангийн аудитын журам, зааврын дагуу гүйцэтгэсэн. Эдгээр нь санхүүгийн тайлан материаллаг буруу илэрхийллээс ангид эсэх талаар үндэслэлтэй баталгаа олж авах зорилгоор аудитыг төлөвлөж, гүйцэтгэхийг шаарддаг.

Аудитаар Монгол тэмүүлэл сургуулийн 2019 оны жилийн эцсийн төсвийн гүйцэтгэл, санхүүгийн тайлан дахь үлдэгдэл, ажил гүйлгээний дүн хэмжээ болон илчлэл тодруулга, тус байгууллагын мөрдөж байгаа нягтлан бодох бүртгэлийн бодлого, бүртгэл хөтлөлт, программ хангамж, дотоод хяналтын систем болон удирдлагын хийсэн томоохон тооцооллыг шалгаж, аудитын санал дүгнэлтийг дэмжих нотлох зүйлсийг хангалттай цуглуулсан.

Бидний хийсэн аудит тус санхүүгийн тайлан, тодруулгад санал дүгнэлт өгөх хангалттай, зохистой үндэслэлийг бүрдүүлсэн бөгөөд аудитын дүнд үндэслэсэн санал, зөвлөмжийг аудитын тайланд тусгасан болно.

Үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч нь Төсвийн тухай хуулийн 26 дугаар зүйлийн 26.1–д заасны дагуу тайлант хугацааны санхүүгийн тайлан, тодруулгыг Нягтлан бодох бүртгэлийн болон Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандарт, түүнтэй нийцүүлэн Сангийн сайдын баталсан журам, зааврын дагуу бэлтгэж, тайлагнах үүрэгтэй.

Аудитын дээд байгууллагуудын нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчим, стандарт болон Аудитын олон улсын стандартын дагуу аудит хийж, жилийн эцсийн төсвийн гүйцэтгэл, санхүүгийн тайланд санал дүгнэлт өгөх нь төрийн аудитын байгууллагын үүрэг юм.

САНХҮҮГИЙН АУДИТЫН
ГАЗРЫН ЗАХИРАЛ БӨГӨӨД
ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



Ц.НАРАНЧИМЭГ

Аудитын тайлан

2.1. Оршил

Монгол тэмүүлэл сургуулийн 2019 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын дүн, дүгнэлтийг Монгол тэмүүлэл сургуулийн захирал Д.Төмөрчөдөр Танд танилцуулж байна.

Энэхүү тайланд үйлчлүүлэгчийн санхүү, нягтлан бодох бүртгэл, дотоод хяналтын системд хийсэн үнэлгээний тойм, аудитын явцад илрүүлсэн гол зүйлс, гаргасан шийдлүүд, анхаарал хандуулахуйц асуудал, залруулаагүй материаллаг болон материаллаг бус алдаа зөрчил, тодруулга зэрэг аудитын үр дүн, аудитын дүгнэлтийн хэлбэр, түүний үндэслэлийн талаар тус тус хураангуйлан тэмдэглэв.

Аудитын дүнд үндэслэсэн орлогыг бодитой төлөвлөж, төвлөрүүлэх, төсвийн зарцуулалтыг сайжруулах, бүтэц орон тоо шинэчлэн батлах зөвлөмжүүдийг Менежментийн захидалд тусгасан болно.

2.2. Аудит хийх үндэслэл, зорилго, талуудын хүлээх үүрэг, хариуцлага

Бид Төрийн аудитын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1, 15.2, 18 дугаар зүйлийн 18.2, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Монгол тэмүүлэл сургуулийн 2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болгосон санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Монгол тэмүүлэл сургуулийн 2019 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль болон УСНББОУС, түүнд нийцүүлэн гаргасан төсвийн байгууллагын нягтлан бодох бүртгэлийн бодлого, заавар, журмын дагуу үнэн зөв, шударга илэрхийлэгдсэн эсэхэд дүгнэлт өгөх нь энэхүү аудитын зорилт байв.

Төсвийн шууд захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайлангаа Төсвийн тухай хууль болон УСНББОУС, түүнд нийцүүлэн баталсан төсвийн байгууллагын нягтлан бодох бүртгэлийн бодлого, журмын дагуу үнэн зөв, бодитой бэлтгэх үүрэгтэй.

Харин тухайн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг дээрх хууль болон бодлого, журмын дагуу материаллаг алдаагүй, үнэн зөв, шударга илэрхийлсэн эсэхэд дүгнэлт өгөх нь Төрийн аудитын байгууллагын үүрэг юм.

Аудитыг 2020 оны 02 дугаар сарын 10-аас 2020 оны 2 дугаар сарын 20-ны хооронд гүйцэтгэж, аудитын тайланг 2020 оны 2 дугаар сарын 20-ны өдөр эцэслэн баталгаажуулж, төсвийн шууд захирагчид хүргүүлэхээр төлөвлөн, Санхүүгийн аудитын газрын аудитор С.Отгонхорлоо хариуцаж хэрэгжүүлэв.

Монгол тэмүүлэл сургуулийн 2019 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайланг Үндэсний аудитын газарт 2020 оны 1 дүгээр сарын 23-ны өдрийн 01/07 дугаар бүхий албан бичгээр ирүүлсэн байна.

2.3. Аудитад мөрдсөн бодлого, журам, арга зүй, шалгуур үзүүлэлт

АДБОУС, АОУС, нийтээр хүлээн зөвшөөрсөн бусад зарчимд тулгуурласан Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан Төрийн аудитын байгууллагаас санхүүгийн тайланд аудит хийх журам, аудитад баримтлах ерөнхий чиглэл, арга зүйг мөрдөн ажиллав.

Дээрх стандарт, зарчим, журамд нийцүүлж аудитын үе шатны ажлыг гүйцэтгэж, холбогдох ажлын баримт материалаар баталгаажуулсан болно.

2.4. Байгууллагын зорилго, үйл ажиллагаа, хууль, эрх зүйн орчин

Монгол тэмүүлэл сургуулийн үйл ажиллагааны эрхэм зорилгоо чанартай боловсрол олгож, дэлхийд өрсөлдөхүйц чадвартай Монгол иргэнийг бэлтгэхэд оршино гэж тодорхойлсон.

Дээрх зорилгын хүрээнд үйл ажиллагааны чиглэлийг дараах байдлаар тодорхойлжээ. Үүнд:

- Аливаа үйл ажиллагаа нь хууль эрх зүйн хүрээнд сургалтын чанараар тэргүүлэх, олон улсад амжилт гаргаад байгаа багшийг бүх талаар дэмжих;
- Сургалтын материаллаг болон сэтгэлзүйн таатай орчин бүрдүүлэх, үндэсний соёл, өв уламжлалаа дээдлэх, сэргээх, энэ чиглэлээр санаачилгатай байх;
- Сурагчдын бодит чадварыг хөгжүүлэх зорилгоор танхимын бус сургалтыг дэмжиж, хөгжүүлэх;
- Багш, ажилчдын нийгмийн асуудлыг сургуулийн нөөц бололцоонд дээр тулгуурлан шийдвэрлэж байх;
- Монгол улсын “Боловсролын тухай хууль”-ийн 44 дүгээр зүйл, “Бага дунд боловсролын тухай хууль”-ийн 22 дугаар зүйлд тус тус дурдагдсан эрх үүргээ биелүүлж, багшийн ёс зүйн дүрэм болон холбогдох хууль дүрэм журмыг өөрсдийн ажилдаа мөрдлөг болгож ажиллах;
- Суралцагчдын сонголтод тулгуурлан олон улсын хөтөлбөрийг амжилттай хэрэгжүүлэхэд онцгой анхаарч ажиллах;
- Төлөвлөж буй бүхий үйл ажиллагаа нь сурагчдын бүтээлч сэтгэлгээг хөгжүүлэхэд чиглэгдэх;
- Мэргэжлийн англи хэл болон ур чадвараа тасралтгүй сайжруулах;
- Суралцагчдын эцэг эхтэй нягт холбоотой байж тэдэнд зөвлөн туслах, хамтарч ажиллах зарчим баримтлах;

Тайлант хугацаанд байгууллагын санхүүгийн үйл ажиллагаанд мөрддөг хууль, тогтоомж, бодлого, журамд өөрчлөлт орсон байна. Үүнд:

- “Төрийн үйлчилгээний албан тушаалын зэрэглэлийг шинэчлэн тогтоох тухай” 2019 оны Засгийн газрын 276 тогтоол;
- “Төрийн албан хаагчийн албан тушаалын цалингийн сүлжээ, хэмжээг шинэчлэн тогтоох тухай” 2019 оны Засгийн газрын 24-р тогтоол;
- “Төрийн албан хаагчийн ёс зүйн дүрэм батлах” 2019 оны Засгийн газрын 33-р тогтоол;

2.5. Нягтлан бодох бүртгэлийн бодлого, санхүүгийн үйл ажиллагаа болон дотоод хяналттай холбоотой хүчин зүйлсийн үнэлгээ

Бид санхүүгийн тайланд материаллаг алдаа байхгүй гэдгийг нягтлах үүднээс үйлчлүүлэгчийн нягтлан бодох бүртгэлийн бодлого, санхүүгийн үйл ажиллагаа, дотоод хяналтыг шаардлагатай гэж үзсэн хэмжээгээр дахин хянасан болно.

Тус Монгол тэмүүлэл сургуулийн мөрдөж байгаа Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нь Сангийн яамнаас хэрэгжүүлж байгаа нягтлан бодох бүртгэлийн бодлого, холбогдох стандарт, хууль тогтоомжтой нийцсэн байна.

Монгол тэмүүлэл сургууль нь санхүү, нягтлан бодох бүртгэлийн үйл ажиллагаанд “Acolous” программ хангамж ашигладаг байна.

Монгол тэмүүлэл сургуулийн дотоод хяналтын эрсдэлийг төлөвлөлтийн үе шатанд “дунд” гэж үнэлсэн бөгөөд гүйцэтгэлийн шатанд дахин хянахад дотоод хяналт үр нөлөөтэй байна.

2.6. Төлөвлөлтийн шатанд тодорхойлсон эрсдэл, түүнийг үнэлсэн байдал

Аудитаар Монгол тэмүүлэл сургуулийн бэлтгэсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл нь материаллаг хэмжээний алдаатай илэрхийлэгдээгүй гэсэн үндэслэлтэй нотолгоо олж авахын тулд байгууллагын гадаад дотоод орчин, дотоод хяналтыг судлан, эрсдэлтэй асуудлыг илрүүлж, үнэллээ.

Аудитын төлөвлөлтийн үе шатанд 7 эрсдэлтэй асуудалд горим сорил хэрэгжүүлэхээр төлөвлөж баталгаажуулсан болно.

2.7. Материаллаг байдлын суурь сонгосон үндэслэл, тайлбар

Аудитыг төлөвлөх үе шатны материаллаг байдлыг АДБОУС 1320, АОУС 320-ын дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр 2019 оны жилийн эцсийн үр дүнгийн тайлангийн нийт зардлыг сонгож, эрсдэлийн түвшинг “дунд” гэж үнэлэн материаллаг байдлын хувь хэмжээг 1 хувиар тогтоов.

Төлөвлөлтийн үе шатанд сонгосон суурь үзүүлэлтийн дүн 1,281,545.5 мянган төгрөгөөс тооцон 12,815.5 мянган төгрөгөөр материаллаг байдлын түвшнийг тодорхойлж, баталгаажууллаа.

Гүйцэтгэлийн үе шатанд материаллаг байдлын түвшнийг өөрчлөхгүй гэж үзлээ.

2.8. Санхүүгийн тайлангийн үзүүлэлтүүд

Монгол тэмүүлэл сургуулийн 2019 оны жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлангаарх нийт хөрөнгийн дүн өмнөх оноос 178,827.3 мянган төгрөгөөр буюу 12.4 хувиар буурсан байна.

Хүснэгт 1. Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өөрчлөлт
Б	1	2	3=2-1
Мөнгөн хөрөнгө	0.1	-	(0.1)
Авлага	-	303.7	303.7
Бараа материал	136,745.6	138,899.2	2,153.60
Үндсэн хөрөнгө	4,181,994.4	4,000,709.8	(181,284.5)
Нийт хөрөнгө	4,318,740.1	4,139,912.8	(178,827.3)
Засгийн газрын оролцоо /Эздийн өмч/	4,318,740.1	4,139,912.8	(178,827.3)
Нийт өр төлбөр ба цэвэр хөрөнгө өмчийн дүн	4,318,740.1	4,139,912.8	(178,827.30)

Өмнөх оны үзүүлэлтээс бараа материал, үндсэн хөрөнгийн дансанд материаллаг өөрчлөлт гарсан байна. Тухайлбал

Бараа материалын дансны үлдэгдэл өссөн нь 11,708.7 мянган төгрөгийн 95 нэр төрлийн материал, (үдийн цай, хүүхдийн хоолны материал химийн хичээлийн урвалжууд) бэлтгэсэнтэй холбоотой байна.

Үндсэн хөрөнгө дансны үлдэгдэл 181,284.5 мянган төгрөгөөр буурсан нь тайлант хугацаанд байгуулсан хуримтлагдсан элэгдлээс шалтгаалжээ. Үндсэн хөрөнгө хөрөнгө оруулалтаар 20,150.6 мянган төгрөг, хандиваар болон үнэ төлбөргүй хүлээн авсан 25,305.6 мянган төгрөгийн хөрөнгөөр нэмэгдсэн бол байгуулсан элэгдлийн зардлын дүнгээр хорогдсон байна.

2.9. Төсвийн гүйцэтгэлийн талаарх тайлбар, тодруулга

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн шууд захирагч нь энэ хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

Тайлант онд Төсвийн шууд захирагчийн хэрэгжүүлэх 1 хөтөлбөрт зориулан 906,852.8 мянган төгрөгийг урсгал зардлын төсөв батлагдаж, гүйцэтгэлээр 906,852.8 мянган төгрөгийн санхүүжилт авч, 902,373.9 мянган төгрөгийг зарцуулж үлдэгдэл 4,478.9 мянган төгрөгийг улсын төсөвт буцаан төвлөрүүлсэн байна.

Төсвийн нийт зардлын гүйцэтгэл 902,373.9 мянган төгрөг буюу 99.5 хувьтай байгаа нь цалингийн зардал 337.5 мянга, бусдаар гүйцэтгүүлсэн ажил үйлчилгээний зардал 3,989.3 мянган төгрөгийг дутуу зарцуулснаас шалтгаалжээ.

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр харуулсан мэдээллийг энэ тайлангийн 4.5-д харуулав.

Нэмэлт төсөв: Үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого цайны газрын орлого 133 дугаар сургууль 97,405.4 мянга, хүүхдийн хоолны мөнгө 49,127.3 мянга, шалгалтын хураамж 23,790.0 мянга, нийт 170,331.9 мянган төгрөгийн орлогыг бүрдүүлжээ.

Үүнээс үйл ажиллагааны урсгал зардалд 170,139.1 мянган төгрөгийг зарцуулж, үлдэгдэл 199.8 мянган төгрөгийг улсын төсөвт төвлөрүүлсэн байна.

2.10. Аудитаар хэрэгжүүлсэн горим сорил, түүний үр дүн

Аудитыг төлөвлөх үе шатанд тогтоосон 4 эрсдэл, гүйцэтгэх үе шатанд 1 эрсдэл тодорхойлж нийт 7 горим сорил хэрэгжүүллээ.

Аудитаар нийт 181,081.7 мянган төгрөгийн алдаа зөрчил илэрснээс, 146,591.7 мянган төгрөгийн зөрчилд 1 албан шаардлага хүргүүлж, 34,490.0 мянган төгрөгийн алдаа зөрчлийг арилгах, давтан гаргахгүй байх 3 зөвлөмж өглөө. Үүнээс

Холбогдох эрх бүхий байгууллага, албан тушаалтны шийдвэргүй, туслах үйл ажиллагааны орлогыг төлөвлөж, батлуулалгүйгээр цайны газрын үйл ажиллагаа явуулан 146,532.7 мянган төгрөгийн орлого бүрдүүлж зарцуулсан байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1.9-д "төсвийн орлого" гэж хууль тогтоомжийн дагуу улсын болон орон нутгийн төсөв бүрдүүлэх орлого, төсвийн байгууллагын өөрийн үйл ажиллагааны орлогыг"; Сангийн сайдын 2019 оны 74 дугаар тушаалын 1.3.1-д "нэмэлт орлого олох үйл ажиллагааг Төсвийн ерөнхийлөн захирагч урьдчилан бичгээр зөвшөөрсөн байх" гэж заасныг тус тус зөрчсөн байна.

Шийдвэрлэсэн нь:

Зөрчлийг арилгах албан шаардлага хүргүүлсэн.

Аудитаар илэрсэн 34,400.0 мянган төгрөгийн алдаа, зөрчилд 3 зөвлөмж өгч, менежментийн захидалд тусгалаа.

2.11. Дараагийн аудитаар авч үзэх буюу анхаарал татахуйц бусад чухал асуудал

Монгол тэмүүлэл сургууль 2017 онд 3,456.9 сая төгрөгийн өртөгтэй хичээлийн байрыг ТӨБЗГ-ын 444 тоот тогтоолын дагуу үндсэн хөрөнгөнд бүртгэжээ. Гэтэл БСШУСС-ын тушаалаар 2020 оны 1 дүгээр сараас 133 дугаар сургуулийг байрлуулж, тус сургуулийг нүүлгэн шилжүүлж Худалдаа үйлдвэрлэлийн дээд сургуулийн байранд түр байрлуулж, түрээсийн зардлыг БСШУСЯ-аас шийдвэрлэхээр болжээ. Байгууллагын үйл

ажиллагаанд сөргөөр нөлөөлж байгаа дээрх асуудалд шат шатны төсвийн захирагч нар анхаарлаа хандуулах шаардлагатай байна.

2.12. Шилэн дансны мэдээлэл

Монгол тэмүүлэл сургууль нь Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан Байгууллагын цахим хуудас www.eec.mn шилэн дансны сайтад байгууллагын тухайн жилийн төсөв, гүйцэтгэл, цалингаас бусад 5 сая төгрөгөөс дээш орлого, санхүүжилт, бараа, ажил үйлчилгээ, ажил үйлчилгээний тушаалууд болон бусад 27 мэдээллийг хугацаанд нь, 2 мэдээллийг хугацаа хоцроож байршуулсан байна.

2.13. Өмнөх аудитаар өгсөн акт, албан шаардлага, зөвлөмжийн хэрэгжилт

Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар 4 зөвлөмж өгснөөс 3 зөвлөмжийг хэрэгжүүлж, 1 зөвлөмж хэрэгжих шатанд, зөвлөмжийн хэрэгжилт 90 хувьтай байна.

Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилтийг тухай бүр бүрэн оруулж хэвшээгүй, хугацаа хоцруулж оруулсан 9 мэдээлэл байгаа нь шилэн дансны тухай хуулийн хэрэгжилтийг бүрэн хангаж ажиллаагүй байна.

2.14. Дүгнэлтийн хэлбэр, үндэслэл

Бид Монгол тэмүүлэл сургуулийн 2019 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайланд аудит хийж, баталгаажуулах ажлыг АДБОУС-ын дагуу, Монгол Улсын холбогдох хууль тогтоомжид нийцүүлэн гүйцэтгэсэн.

Монгол тэмүүлэл сургуулийн 2019 оны жилийн эцсийн санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, мөнгөн гүйлгээ, өмчийн өөрчлөлт болон бусад илчлэл тодруулгыг холбогдох хууль, УСНББОУС-ын дагуу материаллаг байдлын хувьд үнэн зөв, бодитой илэрхийлсэн эсэхийг Аудитын гэрчилгээнд тодорхой дурдав.

3. Менежментийн захидал

Төрийн аудитын байгууллага санхүүгийн тайлангийн аудит бүрийн төгсгөлд аудитаар илрүүлсэн зүйлсийг нэгтгэсэн менежментийн захидлыг үйлчлүүлэгч, түүний удирдлагад зориулж бэлтгэдэг бөгөөд түүнд санхүү, нягтлан бодох бүртгэл, тайлагналын бодлого, үйл ажиллагаа, дотоод хяналтыг сайжруулах зөвлөмжийг тусгадаг.

Энэхүү менежментийн захидлын агуулга АДБОУС болон аудитын үр дүн, дүгнэлтээс урган гарсан болно. Санхүүгийн тайлан, бусад илчлэл тодруулгын талаар санал дүгнэлт гаргахад бидний бодлого, горим зориулагдсан.

Энэ нь нягтлан бодох бүртгэлийн бодлого, горимыг зөвхөн аудитыг үр нөлөөтэй гүйцэтгэхэд шаардагдах цар хүрээнд дахин хянасан бөгөөд оршиж буй бүх сул талыг гаргаж ирэх боломжгүй юм.

Тиймээс аудитын тайланд тусгасан зөвлөмж нь аудит хийх үеийн нөхцөл байдлын талаарх бидний үнэлэлт, дүгнэлтийг илэрхийлж байгаа болно.

Харин эдгээр зөвлөмжийг та бидний хамтын ажиллагааны байр сууринаас гаргасан бөгөөд аудитаар өгсөн зөвлөмжийг хүлээн авч, хэрэгжүүлэх нь танай үүрэг хариуцлага юм.

Менежментийн захидалд дурдсан цаашид санхүүгийн тайланд шууд бөгөөд материаллаг хэмжээгээр нөлөөлж болзошгүй тул анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлоор нь эрэмбэлэн үзүүлэв. Үүнд:

1. Орлоготой холбоотой асуудал

1.1 Илрүүлэлт:

Үндсэн үйл ажиллагааны орлогын төлөвлөгөө батлуулалгүйгээр 23,790.0 мянган төгрөгийн орлого бүрдүүлж нэмэлт санхүүжилтийн дансанд төвлөрүүлэн зарцуулсан байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 31 дүгээр зүйлийн 31.4.2-д "төсвийн байгууллагын өөрийн үйл ажиллагааны орлогын тооцоо", 46 дугаар зүйлийн 46.2-т "Энэ хуулийн 46.1-д заасан төсвийг зарцуулах, тайлагнах, нягтлан бодох бүртгэлд тусгах, хяналт тавих журмыг санхүү, төсвийн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн батална", Сангийн сайдын 2019 оны 74 дүгээр тушаалаар баталсан "Төсвийн зарлагын хэмнэлт, үндсэн үйл ажиллагааны нэмэлт орлогыг зарцуулах, тайлагнах, нягтлан бодох бүртгэлд тусгах, хяналт тавих журам"-ын 3.4.3-т "үндсэн үйл ажиллагааны буюу байгууллагын чиг үүргийг хэрэгжүүлэх явцад бий болдог жил бүр давтагдах шинжтэй тогтмол орлогыг төсөвт тусгахгүй орхигдуулах" гэж заасныг тус тус мөрдөөгүй, тохиолдсон байх, үнэн зөв байх, иж бүрэн байх батламж мэдэгдлүүдийг хангахгүй байна.

1.2 Эрсдэл:

Орлогын төлөвлөгөө тасрах, журам зааврыг хэрэгжүүлэн ажиллаагүй байх;

1.3 Өгсөн зөвлөмж:

Үндсэн үйл ажиллагааны орлогын төлөвлөгөөг батлуулж, төвлөрүүлж ажиллах;

1.4 Байгууллагаас өгсөн хариу тайлбар:

Өгсөн зөвлөмжийг хэрэгжүүлэн ажиллана.

2. Бүтэц орон тоотой холбоотой асуудал

2.1 Илрүүлэлт:

Одоогийн байдлаар 45 бүтэц орон тоотой ажиллаж байгаа нь БСШУСС-н 2011 оны 370 дугаар тушаалаар батлагдсан орон тооноос 19 албан хаагчаар илүү ажиллаж байна. Бүтэц орон тоог дахин шинэчлэн баталж, тогтоогоогүй байна.

Энэ нь Бага, дунд боловсролын тухай хуулийн 12 дугаар зүйлийн 12.10-д "Төрийн өмчийн ерөнхий боловсролын сургуулийн багтаамж буюу хүүхдийн тоо, хэв шинж, ангиллыг харгалзан багшаас бусад захиргааны удирдлага, боловсролын бусад ажилтны орон тооны жишиг нормативыг боловсролын болон төсвийн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн хамтран батална", БСШУСС, Сангийн сайдын 2018 оны А/024/11 дүгээр хамтарсан тушаалаар баталсан "Орон тооны жишиг норматив батлах тухай" хавсралтын 2-д "Ерөнхий боловсролын сургууль /1-12 дугаар ангитай, 10-12 дугаар ангитай/ 161-320 суралцагчийн тоонд хамаарах албан тушаалтны жагсаалт..."-тай тус тус нийцэхгүй, үнэн зөв байх, иж бүрэн байх батламж мэдэгдлүүдийг хангахгүй байна.

2.2 Эрсдэл:

Батлагдсан төсөв хүрэлцэхгүй байх, төсвийн хэрэгжилтийг хангахгүй байх;

2.3 Өгсөн зөвлөмж:

Холбогдох эрх бүхий байгууллага албан тушаалтнаар бүтэц орон тоог шинэчлэн батлуулж, мөрдөж ажиллах;

2.4 Байгууллагаас өгсөн хариу тайлбар:

Өгсөн зөвлөмжийг хэрэгжүүлэн ажиллана.

3 Зарцуулалттай холбоотой асуудал

3.1. Илрүүлэлт:

Тус сургууль нь гадаад, монгол багш нарыг цагийн багшаар авч сурагчдад хичээл заалгадаг боловч, 1 цагийн хөлсийг харилцан адилгүй буюу 10.0-60.0 мянган төгрөгөөр тогтоож нийт 10,700.0 мянган төгрөгийн цалинг олгосон байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.1-д "төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах" гэж заасантай нийцэхгүй байна.

3.2. Эрсдэл:

Батлагдсан төсөв хүрэлцэхгүй болох, журам зааврыг мөрдөн ажиллах;

3.3. Өгсөн зөвлөмж:

Багшийн 1 цагийн үнэлгээг тогтоох үндэслэлийг тодорхой болгох заавар, журмыг мөрдөж ажиллах;

3.4. Байгууллагаас өгсөн хариу тайлбар:

Өгсөн зөвлөмжийг хэрэгжүүлэн ажиллана.

Дээрх зөвлөмжийн биелэлтийг төрийн аудитын байгууллагад 2020 оны 6 дугаар сарын 10-ны өдрийн дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

4.Аудит хийсэн санхүүгийн тайлан

4.1Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

Тайлант хугацаа: 2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

/төгрөг/

Дансны код	Балансын үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
1	ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН	136,745,715.66	139,202,939.53
31	МӨНГӨН ХӨРӨНГӨ	110.00	-
311	Кассанд байгаа бэлэн мөнгө	110.00	-
31110	Төгрөг	110.00	-
33	АВЛАГА	-	303,742.37
335	Бусад авлага	-	303,742.37
3351	Байгууллагаас авах авлага	-	303,742.37
35	БАРАА МАТЕРИАЛ	136,745,605.66	138,899,197.16
354	Хангамжийн материал	136,745,605.66	138,899,197.16
35410	Бичиг хэргийн материал	1,733,302.00	1,199,667.00
35420	Аж ахуйн материал	126,170,835.66	126,931,655.16
35440	Түлш, шатах тослох материал	-	77,805.00
35460	Хүнсний материал	18,778.00	1,686,080.00
35470	Бусад хангамжийн материал	8,822,690.00	9,003,990.00
2	ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН	4,181,994,429.09	4,000,709,888.40
39	ҮНДСЭН ХӨРӨНГӨ	4,181,994,429.09	4,000,709,888.40
392	Биет хөрөнгө	4,177,263,104.89	3,997,837,433.51
39201	Барилга, байгууламж, орон сууц	3,456,901,301.72	3,456,901,301.72
39202	Хуримтлагдсан элэгдэл	(70,629,060.74)	(131,168,255.66)
39203	Авто-тээврийн хэрэгсэл	98,458,333.00	98,458,333.00
39204	Хуримтлагдсан элэгдэл	(76,578,703.60)	(92,988,425.80)
39205	Машин тоног төхөөрөмж (компьютер)	176,501,709.44	195,301,089.44
39206	Хуримтлагдсан элэгдэл	(62,029,153.34)	(102,612,699.52)
39207	Тавилга, аж ахуйн эд хогшил	164,372,969.90	170,879,233.90
39208	Хуримтлагдсан элэгдэл	(95,790,650.81)	(115,575,355.21)
39214	Бусад үндсэн хөрөнгө	653,998,698.28	653,998,698.28
39215	Хуримтлагдсан элэгдэл	(78,649,838.96)	(146,063,986.64)
39217	Ном	10,707,500.00	10,707,500.00
393	Биет бус хөрөнгө	4,731,324.20	2,872,454.89
39301	Программ хангамж	6,627,546.00	6,627,546.00
39302	Хуримтлагдсан элэгдэл	(1,896,221.80)	(3,755,091.11)
3	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II	4,318,740,144.75	4,139,912,827.93
5	ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН	4,318,740,144.75	4,139,912,827.93
51	Засгийн газрын хувь оролцоо	4,318,740,144.75	4,139,912,827.93
511	Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан	265,942,620.50	265,942,620.50
51101	Өмч: - төрийн	265,942,620.50	265,942,620.50
512	Хуримтлагдсан үр дүн	4,052,797,524.25	3,873,970,207.43
51210	Өмнөх үеийн үр дүн	4,052,797,524.25	4,052,797,524.25
51220	Тайлант үеийн үр дүн	-	(178,827,316.82)
6	ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V	4,318,740,144.75	4,139,912,827.93

4.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

Тайлант хугацаа: 2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

/төгрөг/

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)	952,172,707.04	1,102,740,204.00
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	83,941,227.04	25,555,644.00
120	Нийтлэг татварын бус орлого	83,941,227.04	25,555,644.00
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	83,941,227.04	25,555,644.00
1200042	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	840,000.00	-
1200045	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого	83,101,227.04	25,555,644.00
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	868,231,480.00	1,077,184,560.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	91,364,680.00	170,331,760.00
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	80,304,680.00	-
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	11,060,000.00	170,331,760.00
1330	Төсвийн захирагчдаас	776,866,800.00	906,852,800.00
133001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	776,866,800.00	906,852,800.00
2	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН	1,042,363,249.12	1,281,545,520.82
21	УРСГАЛ ЗАРДАЛ	1,042,363,249.12	1,281,545,520.82
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	1,041,523,219.01	1,235,787,644.60
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	591,464,277.00	731,412,247.00
210101	Үндсэн цалин	591,464,277.00	731,412,247.00
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	70,016,290.17	89,944,798.63
210201	Тэтгэврийн даатгал	47,378,846.34	59,201,363.64
210202	Тэтгэмжийн даатгал	6,009,012.00	6,955,420.00
210203	ҮОМШӨ-ний даатгал	4,726,569.00	6,878,625.00
210204	Ажилгүйдлийн даатгал	1,092,694.00	1,537,605.00
210205	Эрүүл мэндийн даатгал	10,809,168.83	15,371,785.00
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	49,714,445.00	50,966,457.45
210301	Гэрэл, цахилгаан	23,879,043.00	27,854,740.00
210302	Түлш, халаалт	17,142,555.00	13,793,986.32
210303	Цэвэр, бохир ус	8,692,847.00	9,317,731.13
2104	Хангамж, бараа материалын зардал	15,857,238.60	19,888,148.73
210401	Бичиг хэрэг	1,037,700.00	1,301,740.00
210402	Тээвэр, шатахуун	4,711,030.00	3,004,760.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	5,895,226.00	9,914,654.23
210404	Ном, хэвлэл	-	580,000.00
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	1,548,000.00	1,924,000.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	2,665,282.60	3,162,994.50
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	353,000.00	-
210601	Багаж, техник, хэрэгсэл	353,000.00	-
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	78,445,658.00	101,920,204.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	76,284,358.00	101,592,804.00
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	2,000,000.00	00.00
210803	Даатгалын үйлчилгээ	-	200,000.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	128,300.00	127,400.00
210805	Тээврийн хэрэгслийн оношилгоо	33,000.00	-
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	235,672,310.24	241,655,788.79
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	2,669,700.00	-
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	33,042,004.63	35,065,604.10
210903	Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол	199,960,605.61	206,590,184.69
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	840,030.11	45,757,876.22
2132	Бусад урсгал шилжүүлэг	-	41,079,100.00
213207	Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж	-	20,079,100.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	-	21,000,000.00
2133	Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг	840,030.11	4,678,776.22
213303	Төвлөрүүлэх шилжүүлэг	840,030.11	4,478,941.22
213305	Төвлөрүүлэх шилжүүлэг	-	199,835.00
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (3)=(1)-(2)	(90,190,542.08)	(178,805,316.82)
145	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ОРЛОГЫН ДҮН	-	-
225	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ЗАРДЛЫН ДҮН	1,748,751.68	22,000.00
225001	Үндсэн хөрөнгө худалдсаны гарз	672,920.68	-
225005	Үнэ төлбөргүй гарсан зардал	1,075,831.00	22,000.00
4	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ҮР ДҮН (4)=(145-225)	(1,748,751.68)	(22,000.00)
5	НИЙТ ҮР ДҮН (5)=(3)+(4)	(91,939,293.76)	(178,827,316.82)

4.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

Тайлант хугацаа: 2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

/төгрөг/

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ГҮЙЛГЭЭ	-	-
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (1)	869,071,480.00	1,077,184,560.00
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	840,000.00	-
120	Нийтлэг татварын бус орлого	840,000.00	-
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	840,000.00	-
1200042	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	840,000.00	-
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	868,231,480.00	1,077,184,560.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	91,364,680.00	170,331,760.00
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	80,304,680.00	-
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	11,060,000.00	170,331,760.00
1330	Төсвийн захирагчдаас	776,866,800.00	906,852,800.00
133001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	776,866,800.00	906,852,800.00
2	НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (2)	854,739,210.00	1,077,184,670.00
21	УРСГАЛ ЗАРДАЛ	854,739,210.00	1,077,184,670.00
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	853,899,179.89	1,031,426,793.78
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	589,811,799.66	731,412,247.00
210101	Үндсэн цалин	291,684,968.00	447,118,047.00
210102	Нэмэгдэл	159,885,862.00	159,416,300.00
210103	Унаа хоолны хөнгөлөлт	34,320,000.00	30,520,000.00
210104	Урамшуулал	103,920,969.66	94,357,900.00
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	70,777,500.00	90,248,541.00
210201	Тэтгэврийн даатгал	49,336,800.00	59,505,106.00
210202	Тэтгэмжийн даатгал	4,931,840.00	6,955,420.00
210203	ҮОМШӨ-ний даатгал	4,716,175.00	6,878,625.00
210204	Ажилгүйдлийн даатгал	1,072,035.00	1,537,605.00
210205	Эрүүл мэндийн даатгал	10,720,650.00	15,371,785.00
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	49,714,445.00	50,966,457.45
210301	Гэрэл, цахилгаан	23,879,043.00	27,854,740.00
210302	Түлш, халаалт	17,142,555.00	13,793,986.32
210303	Цэвэр, бохир ус	8,692,847.00	9,317,731.13
2104	Хангамж, бараа материалын зардал	22,579,300.00	21,716,299.23
210401	Бичиг хэрэг	1,945,643.00	2,493,000.00
210402	Тээвэр, шатахуун	4,711,030.00	3,082,565.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	5,895,226.00	9,914,654.23
210404	Ном, хэвлэл	4,465,490.00	761,300.00
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	1,548,000.00	1,924,000.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	4,013,911.00	3,540,780.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	1,040,000.00	-
210601	Багаж, техник, хэрэгсэл	1,040,000.00	-
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	78,766,093.00	104,874,011.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	76,604,793.00	104,546,611.00

Монгол тэмүүлэл сургуулийн 2019 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	2,000,000.00	-
210803	Даатгалын үйлчилгээ	-	200,000.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	128,300.00	127,400.00
210805	Тээврийн хэрэгслийн оношилгоо	33,000.00	-
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	41,210,042.23	32,209,238.10
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	41,210,042.23	32,209,238.10
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	840,030.11	45,757,876.22
2132	Бусад урсгал шилжүүлэг	-	41,079,100.00
213207	Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж	-	20,079,100.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	-	21,000,000.00
2133	Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг	840,030.11	4,678,776.22
213303	Төвлөрүүлэх шилжүүлэг	840,030.11	4,478,941.22
213305	Төвлөрүүлэх шилжүүлэг	-	199,835.00
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (3)=(1)-(2)	14,332,270.00	-110.00
4	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (4)	-	-
5	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (5)	14,332,160.00	-
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	14,332,160.00	-
2200	Дотоод эх үүсвэрээр	14,332,160.00	-
225102	Биет бус хөрөнгө олж эзэмшихэд төлсөн /ТӨҮГ/	14,332,160.00	-
6	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (6)=(4)-(5)	-14,332,160.00	-
7	САНХҮҮГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ	-	-
8	НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (8)=(3)+(6)+(7)	110.00	-110.00
9	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	-	110.00
10	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	110.00	-

4.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

Тайлант хугацаа: 2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан /төгрөг/

Код	Үзүүлэлт	Засгийн газрын оруулсан капитал	Дахин үнэлгээний нөөц	Хуримтлагдсан дүн	Засгийн газрын хувь оролцооны нийт дүн
C01	2017 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	265,942,620.50	-	(43,152,414.67)	222,790,205.83
C02	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	-	-	-	-
C03	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	265,942,620.50	00.00	-43,152,414.67	222,790,205.83
C04	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт	-	-	-	-
C05	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний бууралт	-	-	-	-
C06	Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз	-	-	-	-
C07	Тайлант үеийн үр дүн	-	-	(17,596,870.22)	(17,596,870.22)
D01	2018 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	265,942,620.50	00.00	4,052,797,524.25	4,318,740,144.75
D02	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	00.00	00.00	-	-
D03	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	265,942,620.50	00.00	4,052,797,524.25	4,318,740,144.75
D04	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт, бууралт	-	-	-	-
D05	Үндсэн хөрөнгийн өсөлт, бууралт	-	-	-	-
D06	Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз	-	-	-	-
D07	Гадаад валютын хөрвүүлэлтийн зөрүү	-	-	-	-
D08	Тайлант үеийн үр дүн	-	-	-178,827,316.82	-178,827,316.82
D09	2019 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	265,942,620.50	00.00	3,873,970,207.43	4,139,912,827.93

4.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

Тайлант хугацаа: 2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

/төгрөг/

Дансны код	Үзүүлэлт	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	Хувь
1	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл		110.00	(110.00)	
2	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	906,852,800.00	902,373,968.78	4,478,831.22	99.5
21	УРСГАЛ ЗАРДАЛ	906,852,800.00	902,373,968.78	4,478,831.22	99.5
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	865,773,700.00	861,294,868.78	4,478,831.22	99.5
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	675,221,100.00	674,883,551.00	337,549.00	100.0
210101	Үндсэн цалин	390,614,300.00	390,589,351.00	24,949.00	100.0
210102	Нэмэгдэл	159,728,900.00	159,416,300.00	312,600.00	99.8
210103	Унаа хоолны хөнгөлөлт	30,520,000.00	30,520,000.00	-	100.0
210104	Урамшуулал	94,357,900.00	94,357,900.00	-	100.0
210105	Гэрээт ажлын хөлс	00.00	00.00	-	0.0
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	83,290,800.00	83,289,900.00	900.00	100.0
210201	Тэтгэврийн даатгал	61,015,000.00	52,715,606.00	8,299,394.00	86.4
210202	Тэтгэмжийн даатгал	5,569,000.00	6,921,592.00	(1,352,592.00)	124.3
210203	ҮОМШӨ-ний даатгал	4,455,200.00	6,836,340.00	(2,381,140.00)	153.4
210204	Ажилгүйдлийн даатгал	1,113,800.00	1,529,148.00	(415,348.00)	137.3
210205	Эрүүл мэндийн даатгал	11,137,800.00	15,287,214.00	(4,149,414.00)	137.3
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	43,066,500.00	43,066,457.45	42.55	100.0
210301	Гэрэл, цахилгаан	16,914,500.00	21,154,740.00	(4,240,240.00)	125.1
210302	Түлш, халаалт	19,352,000.00	13,793,986.32	5,558,013.68	71.3
210303	Цэвэр, бохир ус	6,800,000.00	8,117,731.13	(1,317,731.13)	119.4
210304	Байрны түрээс	00.00	00.00	-	0.0
2104	Хангамж, бараа материалын зардал	19,785,800.00	20,114,799.23	(328,999.23)	101.7
210401	Бичиг хэрэг	3,600,000.00	1,721,500.00	1,878,500.00	47.8
210402	Тээвэр, шатахуун	5,213,900.00	2,982,565.00	2,231,335.00	57.2
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	7,900,000.00	9,664,654.23	(1,764,654.23)	122.3
210404	Ном, хэвлэл	1,071,900.00	281,300.00	790,600.00	26.2
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	1,000,000.00	1,924,000.00	(924,000.00)	192.4
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	1,000,000.00	3,540,780.00	(2,540,780.00)	354.1
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	12,200,000.00	8,210,673.00	3,989,327.00	67.3
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	11,872,000.00	7,883,273.00	3,988,727.00	66.4
210803	Даатгалын үйлчилгээ	200,000.00	200,000.00	-	100.0
210804	Тээврийн хэрэгслийн татвар	128,000.00	127,400.00	600.00	99.5
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	32209500.00	31729488.10	480,011.90	98.5
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	32,209,500.00	31,729,488.10	480,011.90	98.5

Монгол тэмүүлэл сургуулийн 2019 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	41079100.00	41079100.00	-	100.0
2131	Засгийн газрын урсгал шилжүүлэг	00.00	00.00	-	0.0
2132	Бусад урсгал шилжүүлэг	41,079,100.00	41,079,100.00	-	100.0
213207	Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж	20,079,100.00	20,079,100.00	-	100.0
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	21,000,000.00	21,000,000.00	-	100.0
	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	906,852,800.00	902,373,858.78	4,478,941.22	99.5
1310	УЛСЫН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	906,852,800.00	902,373,858.78	4,478,941.22	99.5
131001	Улсын төсвөөс санхүүжих	906,852,800.00	902,373,858.78	4,478,941.22	99.5
4	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	-	110.00	(110.00)	
5	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	-	-		
61	БАЙГУУЛЛАГЫН ТОО	-	-		
610001	Төсвийн байгууллага	-	-		
610002	Төсвөөс гадуур байгууллага	-	-		
62	АЖИЛЛАГСАДЫН ТОО	41	41		
620001	Удирдах ажилтан	1	1		
620002	Гүйцэтгэх ажилтан	31	31		
620003	Үйлчлэх ажилтан	9	9		
620004	Гэрээт ажилтан	-	-		

4.6 Аудит хийсэн нэмэлт санхүүжилтийн тайлан

Тайлант хугацаа: 2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

/төгрөг/

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх он	Гүйцэтгэл
	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	-	-
I	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	-	170,331,760.00
21	УРСГАЛ ЗАРДАЛ	-	170,331,760.00
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	-	170,131,925.00
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	-	56,528,696.00
210101	Үндсэн цалин	-	56,528,696.00
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	-	6,958,641.00
210201	Тэтгэврийн даатгал	-	6,789,500.00
210202	Тэтгэмжийн даатгал	-	33,828.00
210203	ҮОМШӨ-ний даатгал	-	42,285.00
210204	Ажилгүйдлийн даатгал	-	8,457.00
210205	Эрүүл мэндийн даатгал	-	84,571.00
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	-	7,900,000.00
210301	Гэрэл, цахилгаан	-	6,700,000.00
210303	Цэвэр, бохир ус	-	1,200,000.00
2104	Хангамж, бараа материалын зардал	-	1,601,500.00
210401	Бичиг хэрэг	-	771,500.00
210402	Тээвэр, шатахуун	-	100,000.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	-	250,000.00
210404	Ном, хэвлэл	-	480,000.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	-	96,663,338.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	-	96,663,338.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	-	479,750.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	-	479,750.00
213305	Төвлөрүүлэх шилжүүлэг	-	199,835.00
II	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	-	170,331,760.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	-	170,331,760.00
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	-	170,331,760.00
IV	НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (III)=(II)-(I)	-	-
	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	-	-
	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	-	-

5.Аудитын явцад илэрсэн алдаа зөрчлийн нэгтгэл

Аудитын тайлангийн хавсралт

Аудитын явцад илэрсэн алдаа, зөрчлийн жагсаалт

Огноо:	2019 он	Аудитын нэр:	Санхүүгийн тайлангийн аудит	САГ-2020/151/СТА-ТШЗ
Шалгагдсан	Монгол тэмүүлэл сургууль		мянган төгрөгөөр	

№	Алдаа, зөрчлийн товч утга	Мөнгөн дүн /мянган төгрөгөөр/	Аудитын байгууллага ас гаргасан шийдэл	Алдаа, зөрчилтэй асуудал гаргасан албан тушаалтны	
				Албан тушаал	Овог нэр
A	1	2	3	4	5
1	Холбогдох эрх бүхий байгууллага, албан тушаалтны шийдвэргүй, туслах үйл ажиллагааны орлогыг төлөвлөж батлуулалгүйгээр цайны газрын үйл ажиллагаа явуулан 133 дугаар сургуулийн сурагчдад үдийн цай нийлүүлж 97,405.4 мянга, тус сургуулийн хүүхдүүдэд үдийн хоол 49,127.3 мянга, нийт 146,532.7 мянган төгрөгийн орлого бүрдүүлж нэмэлт санхүүжилтийн дансаар дамжуулан зарцуулсан байна.	146,591.7	Албан шаардлага хүргүүлэх	Монгол тэмүүлэл сургуулийн захирал, Нягтлан бодогч	Д.Төмөрчөдөр, Х.Орхончимэг
2	Үндсэн үйл ажиллагааны орлогын төлөвлөгөө батлуулалгүйгээр 23,790.0 мянган төгрөгийн орлого бүрдүүлж нэмэлт санхүүжилтийн дансанд төвлөрүүлэн зарцуулсан байна. 2019 оны 8 дугаар сарын 26-нд шалгалт зохион байгуулж бэлнээр хураан авсан шалгалтын 4,760.0 мянган төгрөгийн орлогыг ажлын 49 хоногийн дараа 10 сарын 31-нд харилцах дансанд тушаасан байна.	23,790.0	Зөвлөмж өгөх	Монгол тэмүүлэл сургуулийн захирал, Нягтлан бодогч	Д.Төмөрчөдөр, Х.Орхончимэг
3	Одоогийн байдлаар 45 бүтэц орон тоотой ажиллаж байгаа нь БСШУСС-н 2011 оны 370 дугаар тушаалаар батлагдсан орон тооноос 19 албан хаагчаар илүү ажиллаж байна. Бүтэц орон тоог дахин шинэчлэн баталж, тогтоогоогүй байна.	-	Зөвлөмж өгөх	Монгол тэмүүлэл сургуулийн захирал, Нягтлан бодогч	Д.Төмөрчөдөр, Х.Орхончимэг
4	Тус сургууль нь гадаад, монгол багш нарыг цагийн багшаар авч сурагчдад хичээл заалгадаг боловч, 1 цагийн хөлсийг харилцан адилгүй буюу 10.0-60.0 мянган төгрөгөөр тогтоож нийт 10,700.0 мянган төгрөгийн цалинг олгосон байна.	10,700.0	Зөвлөмж өгөх	Монгол тэмүүлэл сургуулийн захирал, Нягтлан бодогч	Д.Төмөрчөдөр, Х.Орхончимэг
Дүн		181,081.7			



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР
АЛБАН ШААРДЛАГА

2020 оны 03 дугаар сарын 02

№ 01/61

Улаанбаатар хот

САГ- 2020/151/СТА-ТМЗ

Зөрчил арилгуулах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1, 18 дугаар зүйлийн 18.2-т заасан Үндэсний аудитын газрын бүрэн эрхийн хүрээнд, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Монгол тэмүүлэл сургуулийн 2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болгосон санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:

Холбогдох эрх бүхий байгууллага, албан тушаалтны шийдвэргүй, туслах үйл ажиллагааны орлогыг төлөвлөж, батлуулалгүйгээр цайны газрын үйл ажиллагаа явуулан 146,532.7 мянган төгрөгийн орлого бүрдүүлж зарцуулсан байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1.9-д "төсвийн орлого" гэж хууль тогтоомжийн дагуу улсын болон орон нутгийн төсөв бүрдүүлэх орлого, төсвийн байгууллагын өөрийн үйл ажиллагааны орлогыг"; Сангийн сайдын 2019 оны 74 дугаар тушаалын 1.3.1-д "нэмэлт орлого олох үйл ажиллагааг Төсвийн ерөнхийлөн захирагч урьдчилан бичгээр зөвшөөрсөн байх" гэж заасныг тус тус зөрчсөн байна.

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1.12-т "аудитын явцад илэрсэн төлбөрийг барагдуулах акт тавих, зөрчлийг арилгах албан шаардлага өгөх..." Монгол Улсын Ерөнхий аудиторын 2016 оны А/95 дугаар тушаалаар батлагдсан "Төрийн аудитын байгууллагын акт тогтоох, албан шаардлага өгөхөд баримтлах журам"-ын 4.1-д заасныг тус тус үндэслэн **ШААРДАХ** нь:

1. Холбогдох эрх бүхий байгууллага, албан тушаалтнаар шийдвэр гаргуулан туслах үйл ажиллагааны орлогын төлөвлөгөөг 2020 онд төлөвлөн батлуулж, орлогыг байгууллагын дансанд бүрэн төвлөрүүлдэг байх,
2. Албан шаардлагын биелэлтийг 2020 оны 6 дугаар сарын 10-ны дотор Үндэсний аудитын газарт ирүүлэхийг Монгол тэмүүлэл сургуулийн захирал Д.Төмөрчөдөр, нягтлан бодогч Х.Орхончимэг нарт даалгав.

ӨГСӨН:
САГ-ЫН ЗАХИРАЛ БӨГӨӨД ТЭРГҮҮЛЭХ
АУДИТОР *[Signature]* Ц.НАРАНЧИМЭГ
АУДИТОР *[Signature]* С.ОТГОНХОРЛОО

АЛБАН ШААРДЛАГЫГ:

ЗӨВШӨӨРСӨН:
МОНГОЛ ТЭМҮҮЛЭЛ СУРГУУЛИЙН
ЗАХИРАЛ *[Signature]* Д.ТӨМӨРЧӨДӨР
НЯГТЛАН БОДОГЧ *[Signature]* Х.ОРХОНЧИМЭГ

Акт, албан шаардлагын биелэлт хангагдаагүй тохиолдолд Төрийн аудитын тухай хуулийн 28 дугаар зүйлийн 28.2.2-д "Төрийн аудитын байгууллагаас тавьсан албан шаардлага, төлбөрийн актыг цаг хугацаанд нь биелүүлээгүй тохиолдолд зөрчил гаргасан албан тушаалтныг үүрэгт ажлаас нь халах тухай саналыг төрийн аудитын байгууллага эрх бүхий албан тушаалтанд хүргүүлнэ" гэж заасны дагуу харууцагч албан тушаалтанд харууцлага тооцуулахаар эрх бүхий албан тушаалтанд санал хүргүүлнэ.

\\10.10.10.20\Bichie_Kherep\Alban_Shaardlaga\2020\0303SAG4.Docx

001080195

